

“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ

Хамрах хугацаа: 2023/01/01-2023/03/30

2023оны 03 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Д/д	Хаанаас (Хэнээс) ирүүлсэн	Хүлээн авсан он, сар, өдөр	Агуулга	Шилжүүлсэн газар, алба, ажилтан	Хэрхэн шийдвэрлэсэн	Хариу өгсөн хэлбэр (он, сар, өдөр, амаар болон бичгээр)	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8
1	Б.Ганшагай	2023.02.02	ХУД-ийн, 15 дугаар хороо, Цэнгэлдэх хотхоны 212-р байр нь хоёр лифттэй. Нэг лифт нь эвдэрсэн засагдахгүй удаж байгаа. Өчигдөр ажилладаг нэг лифт нь 11 давхраас дээшээ өгсөж явахдаа 4-н давхар луу шууд унасан асуудал гарсан. Азаар ямар нэгэн хүн бэртэж гэмтээгүй. Уг асуудал нь удаа дараа гарч байгаа бөгөөд холбогдох байгууллагад нь удаа дараа хандсан ч ямар ч арга хэмжээ авч өгөөгүй. Одоо ганцхан лифттэй иргэд маш их хүндрэлтэй, аюултай нөхцөлд амьдарч байна. Иргэдийн амь настай холбоотой уг асуудалд тодорхой арга хэмжээ авч өгч чадахгүй байгаа тул холбогдох төрийн байгууллага нь анхааралдаа авч иргэдийн аюулгүй байдалд анхаарал тавьж өгөх хэрэгтэй байна. Холбогдох харьяа байгууллагад нь уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	Тус байрны лифтний засвар, техник үйлчилгээг "Лифткон" ХХК хариуцан ажилладаг байна. Лифт эзэмшигч байгууллагын хувьд гэрээний дагуу сар бүр техник үйлчилгээг хийлгэдэг бөгөөд техникийн магадлал (оношилгоог)-ыг 2022 оны 08 дугаар сард НМХГ-аар хийлгэсэн байна. Тус лифтний хувьд төгсгөлийн унтраалгад гэмтэл гарсан байсныг засварлан хэвийн ажиллагаанд оруулсан байна.	2023.02.06, амаар (утсаар мэдээлэл өгсөн)	

2	Ц.Энхтөр	2023.02.03	<p>ХУД-ийн,17 дугаар хорооны Кинг таур хотхоны 116-р байрны лифт явуулахгүй 2 сар болж байна. Хөгшин настай, хүүхэд, жирэмсэн эх лифт ашиглаж чадахгүй шатаар явах хүндрэлтэй байна. Нийтийн эрх ашиг зөрчигдөж байна гэж үзэж байгаа тул энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, яаралтай арга хэмжээ авч өгнө үү.</p>	<p>Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг</p>	<p>ХУД-ийн 17 дугаар хорооны Кинг таур хотхоны 116-р байрны лифтийг "Урбан элеватор" ХХК хариуцан ажилладаг бөгөөд моторын эргэлт тоологч (энкодер) шатсаны улмаас тус байрны лифт зогссон байна. Тухайн байрны хувьд анх барилга байгууламжийн тоног төхөөрөмжийн холболтыг хийгээгүйн улмаас лифтний дуудлагын платууд болон моторын эргэлт тоологч (энкодер) удаа дараа шатсан. Лифтний засвар, техник үйлчилгээг хариуцан ажилладаг мэргэжлийн байгууллагын зүгээс барилга байгууламжийн тоног төхөөрөмжийн газардуулгын холболтыг хийлгэж засварлуулах талаар удаа дараа шаардсан боловч лифт ашиглагч байгууллага засварлаагүй байна. Иймд СӨХ-нд хандан барилга байгууламжийн тоног төхөөрөмжийн газардуулгын холболтыг засварлуулан, цаашид лифтний хэвийн ажиллагааг хангуулах талаар шаардлага тавихыг зөвлөж байна.</p>	<p>2023.02.06, амаар (утсаар мэдээлэл өгсөн)</p>	
3	Ц.Мөнхбаатар	2023.02.10	<p>Хан-Уул дүүрэг, 9 дүгээр хороо, 54 дүгээр байрны цахилгаан шат нь ажиллахаа болиод 1 жил болж байна. Тус барилгыг барьсан "Green Resource" ХХК-аас барилгыг хариуцах 3 жилийн хугацаа дууссан гээд ямар ч арга хэмжээ авч өгөөгүй. СӨХ-оос, ХУД-ийн Засаг даргын тамгын газарт хандахаар төсөв гаргах</p>	<p>Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг</p>	<p>ХУД-ийн 9 дүгээр хорооны 54 дүгээр байрны цахилгаан шат нь ашиглалтын шаардлага хангахгүй шинэчлэн солих дүгнэлтийг 2022 оны 12 дугаар сард НМХГ-ын улсын байцаагч гаргасан байна. Тус цахилгаан шат нь ашиглалтын</p>	<p>2023.02.14, амаар (утсаар мэдээлэл өгсөн)</p>	

			<p>боломжгүй гэсэн хариу өгдөг. Энэ чанарын шаардлага хангаагүй байрыг улсын комиссоос ямар хүмүүс нь хүлээж авсан бэ? Би ипотекийн 30 жилийн хугацаатай зээлээр авсан байр шүү дээ. Хотын стандарт, хяналтын газрын Барилга техникийн хяналтын улсын байцаагч Б.Гансүх надтай холбогдсон. Цахилгаан шатын угсарсан Мастер Лифт ХХК дампуурсан байгаа юм байна. Урсгал засвар хийх нь, иж бүрнээр сольсноос ялгаагүй дүнгээр засварлуулах болоод байна гэсэн хариу өгсөн. Манайх жил гаран цахилгаан шатгүй маш удлаа. Улаанбаатар лифт компанид энэ асуудлыг уламжилж өгнө үү.</p>		<p>шаардлага солих шаардлагатай цахилгаан шатны жагсаалтад орсон. Нийслэлийн хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй 120 гаран цахилгаан шат байгаа бөгөөд шинэчлэн солих дарааллын дагуу шинэчлэгдвэл багадаа 1-2 жилийн хугацаа шаардана. Иймд тус тойргоос гарсан УИХ гишүүн болон НИТХ-ын төлөөлөгчид хандаж цахилгаан шат шинэчлэн солиулах асуудлыг шийдвэрлүүлнэ үү.</p>		
4	Х.Цогтбаатар	2023.03.03	<p>БЗД-ийн 18 дугаар хороо, 13-р хороолол, 14 дүгээр байрны 107 тоотын оршин суугч байна. Манай байрны лифтыг оройны 22 цагаас хойш явуулахгүй зогсоогоод байна. Манайх оройн цагаар ойрхон байдаг хэвтрийн өвчтэй аавыгаа эргэж тойрдог, байнга 9 давхар руу явах хүндрэлтэй байна. Лифтыг 24 цагаар явуулж өгнө үү.</p>	<p>Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг</p>	<p>БЗД-ийн 18 дугаар хороо, 14 дүгээр байрны лифт нь ашиглалтын хугацаа дууссан цахилгаан шат дууссан шинэчлэн солих шаардлагатай лифт учраас шөнийн цагаар хяналтгүй ажиллуулсан тохиолдолд аливаа эрсдэл гарах магадлалтай тул ажиллуулах боломжгүй гэсэн хариуг лифт ашиглагч байгууллага өгөөд байна. Тус лифтний ажиллах цагийн хуваарийг лифт ашиглагч байгууллага хариуцан ажилладаг болно.</p>	2023.03.09	<p>амаар (утсаар мэдээлэл өгсөн)</p>
5	Б.Хишигсүх	2023.03.16	<p>БЗД-ийн 18-р хорооны 22/А байрны 4-р орцны цахилгаан шатны ашиглалтын хугацаа дуусаад НЗДТГ-т хүсэлт өгсөн боловч шийдвэрлэж өгөхгүй байна. Бүх шатны байгууллагад хандсан ч шийдвэрлэж өгөхгүй байна. Ашиглалтын хугацаа дууссан ч цахилгаанаа шат ашигласаар байгаа. Энэ асуудлыг</p>	<p>Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг</p>	<p>Нийслэлийн хэмжээнд ашиглалтын хугацаа дууссан болон ашиглалтын шаардлага хангахгүй 130 орчим цахилгаан шат байгаа бөгөөд тус жагсаалтад БЗД-ийн 18 дугаар хорооны 22а байрны 4 дүгээр орцны цахилгаан шат орсон</p>	2023.03.17	<p>амаар (утсаар мэдээлэл өгсөн)</p>

			холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлэж өгнө үү.		байна. Дээрх цахилгаан шатуудыг шинэчлэн солих саналыг НЗДТГ болон харьяа тойргийн төлөөлөгч нарт хүргүүлсэн боловч төсөв, хөрөнгө шийдэгдээгүйн улмаас одоог хүртэл шинэчлэгдэхгүй хүлээгдэж байна.		
--	--	--	--	--	--	--	--

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ДОТООД
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.НАРАНГУА